



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан.

Аудитын код: СНАГ-2025/21/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 260512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: Bat-Erdenes@audit.gov.mn Аудитор: П.Ариунзаяа Утас: 261628 Цахим хаяг: Ariunzayap@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА А.НАРАНТУЯА
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 01/1215

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийг төсвийн хоёр жилийн дамжуулан зарцуулсан 1,619.0 сая төгрөг, Хөдөө орон нутагт таван жилээс дээш хугацаагаар тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад олгох 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг хууль, журамд заасан шалгуурт нийцээгүй албан хаагчдад олгосон 186.4 сая төгрөг, жилийн эцэст 178.9 сая төгрөгийн авлага үүсгэсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 41 дүгээр зүйлийн 41.2.3, 43 дугаар зүйлийн 43.5, 45 дугаар зүйлийн 45.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3, Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.1 дэх заалтуудтай тус тус нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/85 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд 330 сум, 9 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн MNS 5368:2018 стандартын хэрэгжилтийн үзлэгийг зохион байгуулсан байна.

Үзлэгт үйл ажиллагаа явуулж буй 872 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 96.1 хувь буюу 792 нэгжийг хамруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Мал, амьтны гоц халдварт өвчний голомтын тоо 104 болж өмнөх оноос 49 хувиар, халдварын тоо 27,740 болж өмнөх оноос 547 тохиолдлоор буурсан байна. Төлөвлөгөөт арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 60.0 сая толгой мал хамруулахаас 58.4 сая толгой мал хамруулж, гүйцэтгэл 97.0 хувьтай байна.

Бусад асуудал

Тайлант онд “Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт, оношлуурын зөвшөөрөл, бүртгэл, үйлдвэрлэл, баталгаажуулалт, худалдаа, хангамж, хэрэглээ, хяналттай холбогдсон харилцааг зохицуулах зорилт” бүхий Мал, амьтны эм тэжээлийн нэмэлтийн тухай хуулийг Улсын Их Хурлаас баталсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САМБУУНЯМ

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,575,048.8	40,722,788.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,470.0	11,524,727.2
33	АВЛАГА	415,351.0	2,077,942.8
34	УРЬДЧИЛГАА	641.4	205,821.6
35	БАРАА МАТЕРИАЛ	18,150,586.4	26,914,296.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	32,255,367.8	33,961,919.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	32,255,367.8	33,961,919.1
39200	Биет хөрөнгө	29,161,604.0	30,757,219.1
39300	Биет бус хөрөнгө	3,093,763.7	3,204,700.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	50,830,416.5	74,684,707.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	320,159.4	11,538,796.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	320,159.4	11,538,796.1
41300	Өглөг	320,159.4	11,538,796.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	50,510,257.2	63,145,911.1
51	Засгийн газрын хувь оролцоо	50,510,257.2	63,145,911.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	9,675,893.6	9,891,053.6
51200	Хуримтлагдсан үр дүн	36,723,086.0	49,143,579.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,111,277.6	4,111,277.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	50,830,416.5	74,684,707.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	114,583,858.3	132,048,213.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,807,161.6	10,837,341.3
120	Нийтлэг татварын бус орлого	17,807,161.6	10,837,341.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	96,776,696.7	121,210,872.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	99,672,626.7	119,606,530.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	99,672,626.7	119,606,530.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	96,001,374.8	112,141,388.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,219,095.2	31,198,346.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,885,859.2	3,954,856.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	939,082.0	1,137,993.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,273,173.6	1,572,409.2
2105	Нормативт зардал	27,803,986.5	28,813,926.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	532,034.5	501,912.3
2107	Хангамж, бараа материалын зардал	671,287.5	1,532,920.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,424,066.9	37,298,404.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,252,789.3	6,130,619.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,671,252.0	7,465,142.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	14,911,231.5	12,441,683.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	130,757.8	24,764.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	14,780,473.7	12,416,919.0

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	97,982,280.1	134,325,660.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,304,684.4	12,872,875.8
120	Нийтлэг татварын бус орлого	1,304,684.4	12,872,875.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	96,677,595.6	121,452,784.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	97,486,042.6	121,617,685.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	97,486,042.6	121,617,685.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	93,623,958.1	114,041,019.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,244,777.6	31,238,792.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,889,214.4	3,950,398.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	976,088.0	1,149,476.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,057,441.0	1,241,965.7
2105	Нормативт зардал	28,149,200.6	29,728,104.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	889,587.3	1,217,237.0
2107	Томилолт, зочны зардал	673,525.5	1,532,920.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,545,009.0	43,681,560.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	199,114.8	300,565.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,862,084.5	7,576,665.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	496,237.5	12,707,975.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	491,567.5	1,191,717.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	491,567.5	1,191,717.8
2200	Дотоод эх үүсвэрээр	491,567.5	1,191,717.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(491,567.5)	(1,191,717.8)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	4,670.0	11,516,257.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,800.0	8,470.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,470.0	11,524,727.2

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,596,645.0	0	35,596,645.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	111,132.8	0	111,132.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,707,777.7	0	35,707,777.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-319.4	0	-319.4
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	22,325.1	0	22,325.1
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	14,780,473.7	0	14,780,473.7
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,510,257.2	0	50,510,257.2
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	50,510,257.2	0	50,510,257.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,574.9	0	3,574.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,513,832.1	0	50,513,832.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	215,160.0	0	215,160.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	12,416,919.0	0	12,416,919.0
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	63,145,911.1	0	63,145,911.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	109,258,451,800.00	105,840,622,082.45	3,417,829,717.55	96.9
УРСГАЛ ЗАРДАЛ	109,258,451,800.00	105,840,622,082.45	3,417,829,717.55	96.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	105,475,471,600.00	102,268,981,756.92	3,206,489,843.08	97.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,422,034,400.00	29,970,186,077.02	1,451,848,322.98	95.4
Үндсэн цалин	18,082,470,800.00	17,431,448,788.98	651,022,011.02	96.4
Нэмэгдэл	8,589,692,300.00	8,329,503,512.01	260,188,787.99	97.0
Унаа хоолны хөнгөлөлт	2,466,009,100.00	2,309,132,810.08	156,876,289.92	93.6
Урамшуулал	2,283,862,200.00	1,900,100,965.95	383,761,234.05	83.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,039,837,900.00	3,798,683,101.47	241,154,798.53	94.0
Тэтгэврийн даатгал	2,737,649,900.00	2,590,564,386.60	147,085,513.40	94.6
Тэтгэмжийн даатгал	323,574,600.00	301,354,521.98	22,220,078.02	93.1
ҮОМШӨ-ний даатгал	171,298,700.00	184,319,995.03	-13,021,295.03	107.6
Ажилгүйдлийн даатгал	162,148,100.00	145,291,566.05	16,856,533.95	89.6
Эрүүл мэндийн даатгал	645,166,600.00	577,152,631.81	68,013,968.19	89.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,212,210,600.00	1,140,286,865.25	71,923,734.75	94.1
Гэрэл, цахилгаан	324,960,900.00	291,876,970.45	33,083,929.55	89.8
Түлш, халаалт	678,334,600.00	656,711,449.24	21,623,150.76	96.8
Цэвэр, бохир ус	56,337,800.00	48,101,477.16	8,236,322.84	85.4
Байрны түрээс	152,577,300.00	143,596,968.40	8,980,331.60	94.1
Хангамж, бараа материалын зардал	876,973,300.00	865,176,016.51	11,797,283.49	98.7
Бичиг хэрэг	145,490,000.00	145,585,685.00	-95,685.00	100.1
Тээвэр, шатахуун	421,763,100.00	416,251,274.30	5,511,825.70	98.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	96,339,200.00	91,027,357.21	5,311,842.79	94.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,979,200.00	4,760,000.00	219,200.00	95.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	208,401,800.00	207,551,700.00	850,100.00	99.6
Нормативт зардал	26,441,607,000.00	25,788,885,326.73	652,721,673.27	97.5
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,398,220,100.00	25,736,505,647.73	661,714,452.27	97.5
Нормын хувцас, зөөлөн эдлэл	43,386,900.00	52,379,679.00	-8,992,779.00	120.7
Эд хогшил, урсгал засварын зардал	2,007,194,100.00	1,976,668,344.58	30,525,755.42	98.5
Багаж, техник, хэрэгсэл	1,322,407,000.00	1,313,785,018.40	8,621,981.60	99.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	46,453,800.00	46,129,448.00	324,352.00	99.3
Урсгал засвар	638,333,300.00	616,753,878.18	21,579,421.82	96.6
Томилолт, зочны зардал	1,055,850,000.00	1,006,155,393.00	49,694,607.00	95.3
Дотоод албан томилолт	1,055,850,000.00	1,006,155,393.00	49,694,607.00	95.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,173,936,500.00	37,512,372,323.96	661,564,176.04	98.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,837,764,500.00	37,195,846,896.89	641,917,603.11	98.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	23,955,200.00	22,171,700.00	1,783,500.00	92.6
Даатгалын үйлчилгээ	28,753,900.00	24,749,261.07	4,004,638.93	86.1
Тээврийн хэрэгслийн татвар	17,230,800.00	13,703,649.00	3,527,151.00	79.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	4,954,000.00	3,091,800.00	1,862,200.00	62.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,578,400.00	244,075,220.00	6,503,180.00	97.4
Газрын төлбөр	10,699,700.00	8,733,797.00	1,965,903.00	81.6
Бараа үйлчилгээний бусад зардал	245,827,800.00	210,568,308.40	35,259,491.60	85.7
Бараа үйлчилгээний бусад зардал	187,430,900.00	182,385,876.00	5,045,024.00	97.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	58,396,900.00	28,182,432.40	30,214,467.60	48.3

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,782,980,200.00	3,571,640,325.53	211,339,874.47	94.4
Бусад урсгал шилжүүлэг	3,782,980,200.00	3,571,640,325.53	211,339,874.47	94.4
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	123,420,000.00	115,496,990.00	7,923,010.00	93.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	749,551,800.00	632,116,089.74	117,435,710.26	84.3
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,735,247,400.00	2,651,603,745.79	83,643,654.21	96.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	174,761,000.00	172,423,500.00	2,337,500.00	98.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	0	0.00	-
Эргэж төлөгдөх зээл	0	0	0.00	-
Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл	0	0	0.00	-
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	0	0	0.00	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	109,258,451,800.00	117,356,359,278.47	-8,097,907,478.47	107.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	108,209,857,400.00	104,501,502,215.57	3,708,355,184.43	96.6
Улсын төсвөөс санхүүжих	108,209,857,400.00	104,501,502,215.57	3,708,355,184.43	96.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,048,594,400.00	12,854,857,062.90	11,806,262,662.90	1,225.9
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,048,594,400.00	1,337,858,562.88	-289,264,162.88	127.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	11,516,998,500.02	11,516,998,500.02	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	170,000.00	-170,000.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	11,515,907,196.02	11,515,907,196.02	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,638.00	2,416.00	222.00	91.6
БАЙГУУЛЛАГЫН ТОО	24	24	0.00	100.0
Төсвийн байгууллага	24	24	0.00	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,307	1,196	111	91.5
Удирдах ажилтан	25	25	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	1,212	1,102	110	90.9
Үйлчлэх ажилтан	70	69	1	98.6
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,307.00	1,196.00	111.00	91.5
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	948	832	116	87.8
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	359	364	-5.	101.4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл <i>/төгрөгөөр/</i>
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		41,820,635,443.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ		41,810,635,443.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		41,496,296,558.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,268,102,230.29
210101	Үндсэн цалин		128,137,627.92
210102	Нэмэгдэл		912,361,299.25
210104	Урамшуулал		201,096,970.12
210105	Гэрээт ажлын хөлс		26,506,333.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		151,714,959.82
210201	Тэтгэврийн даатгал		112,520,206.42
210202	Тэтгэмжийн даатгал		9,265,089.86
210203	ҮОМШӨ-ний даатгал		10,158,669.86
210204	Ажилгүйдлийн даатгал		4,703,272.70
210205	Эрүүл мэндийн даатгал		15,067,720.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		9,189,565.30
210301	Гэрэл, цахилгаан		88,000.00
210302	Түлш, халаалт		9,101,565.30
2104	Хангамж, бараа материалын зардал		417,915,413.70
210401	Бичиг хэрэг		11,716,670.00
210402	Тээвэр, шатахуун		394,741,271.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		603,672.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		3,030,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		7,823,800.00
2105	Нормативын зардал		3,990,699,108.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		3,969,016,408.60
210502	Хоол, хүнс		3,046,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		18,636,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		159,518,340.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		96,264,950.00
210602	Тавилга		2,763,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		50,840,900.00
210604	Урсгал засвар		9,648,790.00
2107	Томилолт, зочны зардал		733,927,040.00
210701	Гадаад албан томилолт		0
210702	Дотоод албан томилолт		733,927,040.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		34,674,408,244.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		34,674,408,244.57
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		90,821,656.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		89,221,656.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		314,338,884.96

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг		125,836,088.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		125,836,088.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		188,502,796.96
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		186,461,317.08
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		2,041,479.88
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		10,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		10,000,000.00
223001	Бусад хөрөнгө		10,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		41,820,635,443.24
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		41,820,635,443.24
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		278,675,372.21
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,439,996,985.33
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		28,882,749,706.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		219,213,379.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0

3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 11,427.8 сая төгрөгийн 30 алдаа¹ илэрснээс аудитын явцад 11,427.8 сая төгрөгийн 28 алдааг залруулж, алдааг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар нийт 2,389.0 сая төгрөгийн 72 зөрчил² илэрснээс, 53.4 сая төгрөгийн зөрчилд 18 төлбөрийн акт тогтоож, 2,034.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 23 албан шаардлага хүргүүлж, 301.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 31 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар илэрсэн 2,407.4 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 998.0 сая төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөв.

3.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 25 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 19 байгууллагад бие даасан дүгнэлт гаргаж, 6 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна. Харьяа 19 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 11,522.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 11,292.2 сая төгрөгийн 25 алдааг аудитын явцад залруулж, 53.4 сая төгрөгийн 18 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 68.3 сая төгрөгийн 18 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 109.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 27 зөвлөмжийг өгсөн байна.

3.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 135.5 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.Үүнд:

- МЭЭГ болон Биокомбанит ТӨХХК -ийн хооронд 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр "Тусгай зориулалт бүхий хөргүүрт 2023 он, 2024 онд авсан гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцин хадгалах " 2024/135 дугаар бүхий гэрээг байгуулж, 2024 оны 12-р сарын 27-ны өдрөөс 2025 оны 12-р сарын 27-ны хүртэлх хугацаанд сарын 16.3 сая төгрөг, нийт 195.6 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг байгуулж, төлбөрийг 100 хувь шилжүүлж, урьдчилж төлсөн зардлаар бүртгэснээс оны эцэст 97.8 сая төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- МЭЭГ болон Ард даатгал ХХК-ийн хооронд 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр "Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ"-г байгуулж, байгууллагын эзэмшлийн 5 тээврийн хэрэгслийг 1 жилийн хугацаатай даатгуулж, хураамжийн 6.7 сая төгрөгийг урьдчилж төлснийг тайлант жилийн зардалд бүртгэсэн;
- Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас чөлөөлөгдсөн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 1 иргэнд , ажилгүй байх хугацааны цалин, НДШ-ийг нөхөн төлбөрт 31.0 сая төгрөгийг тайлант онд байгууллагын төсвөөс нөхөн төлж зардлаар бүртгэснийг гэм буруутай этгээдээс нэхэмжлэх авлага үүсгэсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитаар нийт 2,158.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1,966.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага хүргүүлж, 192.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн яамны шинээр нэвтрүүлж буй системээр бэлтгэж байсныг хуучин Э-тайлан системээр нэгтгэх болсноор хугацаа шаардсан гэх шалтгаанаар 2024 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 01/279 дугаар албан бичгээр Төрийн аудитын байгууллагад хугацаа хоцроож тайланг ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т “төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй зөрчлийг таслан зогсоох.

2. МЭЭГ болон Биокомбанит ТӨХХК -ийн хооронд 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдөр "Мал эмнэлгийн зориулалт бүхий биобэлдмэлийг худалдах, худалдан авах" 2024/06 дугаартай, нийт 5,006.5 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг байгуулж, 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр гэрээг дүгнэж акт үйлдсэн байна. Мөн 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр талуудын хооронд " Мал эмнэлгийн зориулалт бүхий биобэлдмэл 2024 онд худалдах, худалдан авах МЭЭГ/202406 дугаартай гэрээний нэмэлт" 02 дугаартай гэрээг байгуулж, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, шингэлэгчийн хамт 1,798.9 сая төгрөгөөр 2024 оны 12 дугаар сард нийлүүлэхээр тохиролцож, санхүүжилтийн 90 хувь 1,619.0 сая төгрөгийг нийлүүлэгч талд шилжүүлж, гэрээнд заасан хугацаанд үүргийн биелэлт хангагдаагүй, жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагын үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй", 45 дугаар зүйлийн 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлээгүй, төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулсан зөрчлийг таслан зогсоох.

3. МЭЭГ-ын харьяа байгууллагын сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй 5 жил, түүнээс дээш хугацаагаар ажилласан төрийн захиргааны албан хаагчдад 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгохдоо Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5-д заасныг үндэслэн Төрийн үйлчилгээний албаны ангилал бүхий 28 албан хаагчид 168.1 сая төгрөгийн урамшуулал тооцож олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан

хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.1-т "Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан албан тушаалд томилогдон тасралтгүй 5 жил (60 сар), түүнээс дээш хугацаагаар ажилласан төрийн захиргааны албан хаагч мөнгөн урамшуулал авна", 4.3-т "Байгууллагын удирдлага энэ журмын 4.1-д заасан хүсэлт, 4.2-т заасан баримтыг хянан үзэж төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох шийдвэр гаргана", 5.5-д "Төрийн захиргааны албан хаагчийн сүүлийн 12 сарын үндсэн цалингийн дундаж, төрийн жинхэнэ алба хаасан тасралтгүй хугацааг буруу тодорхойлох, хуурамч баримт бичиг бүрдүүлэх зэргээр мөнгөн урамшууллын хэмжээг буруу тогтоож олгосон албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэж, хохирлыг буруутай этгээдээр төлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөө, орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдлийг холбогдох, хууль журмын дагуу тооцож олгоогүй зөрчлийг таслан зогсоох.

4. МЭЭГ-ын даргын 2024 оны А/82 дугаар тушаалаар "Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөө"-г баталсан байна. Төлөвлөгөөнд үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтад 968.2 мянган толгой үхэр хамруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 34.4 мянган толгой үхэр хамруулж, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтад 13,708.5 мянган толгой үхэр, гахай, цаа буга хамруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 6,683.3 мянган толгой мал, амьтныг хамруулж төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, жилийн эцсийн санхүүгийн тайланд их хэмжээний вакцины үлдэгдэлтэй байна.

Энэ нь Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д "мал эмнэлгийн үйлчилгээний мэргэжлийн, шуурхай, бие даасан, нэгдмэл байдлыг хангах", 9 дүгээр зүйлийн 9.2-т "Эрсдэл ихтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараа онд хийгдэх төлөвлөгөөт дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан энэ хуулийн 28.9-д заасан зөвлөлөөр хэлэлцүүлж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мал, амьтны гоц халдварт үхрийн арьс товруутах, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг төлөвлөсөн хэмжээнд зохион байгуулж, гүйцэтгээгүй зөрчлийг арилгах.

5. МЭЭГ-нь Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд шинээр 178.9 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаагүйгээс жилийн эцсийн тайлангаар авлага үүсгэсэн зөрчлийг арилгах.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас чөлөөлөгдсөн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 3 албан хаагчид, ажилгүй байх хугацааны цалин, НДШ-ийн нөхөн төлбөрт 34.7 сая төгрөгийг өмнөх онд байгууллагын төсвөөс нөхөн төлснийг гэм буруутай этгээдээр төлүүлэх авлага үүсгэснийг барагдуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шүүхийн шийдвэрийн байгууллагын төсвөөс олгосон нөхөн төлбөрийг хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлж төрийг хохиролгүй болгох арга хэмжээг авах.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: МЭЕГ-ын бусад материалын дансанд өмнөх оноос зарцуулагдаагүй хугацаа дууссан мялзан, боом хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, шингэлэгч зэрэг 124.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмнөх оноос шилжин ирсэн хугацаа нь дууссан мал, амьтны вакцин, шингэлэгчийг устгалд оруулах.

3. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу үндэслэлтэй төлөвлөж, хянуулаагүйгээс мал эрүүлжүүлэх арга хэмжээний бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас агентлагийн албан томилолтын зардлыг санхүүжүүлж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.3-т "төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх; 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай тус тус нийцээгүй байна

Өгсөн зөвлөмж: Агентлагийн 2026 оны Төсвийн төсөлд төсвийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу төсвийг хөтөлбөр зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал бүрээр үндэслэлтэй төлөвлөж, хянуулах.

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Мал амьтан эрүүлжүүлэх арга хэмжээний Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 32.9 сая төгрөгийн хөрөнгийн шинж чанартай худалдан авалтыг авалтыг гүйцэтгэсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д " батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсөв, зарцуулах эрхийн дагуу тохирох эдийн засгийн ангиллаас багаж, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийж байх.

4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар нийт 1,756.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 40.2 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1,716.1 сая төгрөгийн зөрчилд 9 зөвлөмж хүргүүлсэн.

4.1.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааны цахим системд бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, гэрээ дүгнэсэн актын талаарх мэдээллийг оруулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 9 дүгээр зүйлийн 9.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ”, 48 дугаар зүйлийн 48 дугаар зүйлийн 48.2.7-т “худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны цахим системд худалдан авах гэрээ, гэрээний хэрэгжилтийг мэдээлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.1.2 Зөвлөмж

Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны цахим системд нийт 9 мэдээллийг хугацаа хоцроож, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн 2, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 1, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийн 10, зэрэг мэдээллийг огт мэдээлээгүй, Төсвийн шууд захирагчийн Шилэн дансны цахим хуудсанд хандив, тусламжаар хүлээн авсан бог малын мялзан, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин болон ариутгалын бодис зэрэг 1,668.3 сая төгрөгийн хандив, тусламжийн орлого, түүний зарцуулалтын тайланг, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 5-12 сарын мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6 дугаар зүйлийн 6.3.5-д “хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт”, 6.4.1-д “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг тухай бүр бүрэн, цаг хугацаанд нь байршуулаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт2: МЭЕГ-ын харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн 230.6 сая төгрөг, нийцлийн аудитын асуудлаар 88.0 сая төгрөг, нийт 318.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 53.4 сая төгрөгийн 18

зөрчилд төлбөрийн акт тогтоож, 108.4 сая төгрөгийн 20 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 156.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 33 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, 6 дугаар зүйлийн 6.6.1-д " төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4- т "Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын 2024 оны аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүлэв.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

5.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

д/д	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
								Үүнээс					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Говь-Алтай амйгийн МЭГ	1	350,918.0			1.0	350,918.0	1	350,918.0	-	-	-	-
2	Говьсүмбэр аймгийн МЭГ	4	4,657.4			4.0	4,657.4	2	4,657.4	2.0	-	2.0	-
3	Дундговь аймгийн МЭГ	3	205,641.2			3.0	205,641.2	3	205,641.2	-	-	-	-
4	Завхан аймгийн МЭГ	3	1,484,135.3			3.0	1,484,135.3	3	1,484,135.3	-	-	-	-
5	Мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	1	949.7			1.0	949.7	1	949.7	-	-	-	-
6	Мал эмнэлгийн ерөнхий газар ТШЗ	3	135,539.0	1	31,021.1	2.0	104,517.9	3	135,539.0	-	-	-	-
7	Нийслэлийн МЭГ	2	18,587.4			2.0	18,587.4	2	18,587.4	-	-	-	-
8	Төв аймгийн МЭГ	6	2,332,023.6			6.0	2,332,023.6	6	2,332,023.6	-	-	-	-
9	Ховд аймгийн МЭГ	2	163,721.9	1	83,542.1	1.0	80,179.8	2	163,721.9	-	-	-	-
10	Хөвсгөл аймгийн МЭГ	3	6,559,679.5			3.0	6,559,679.5	3	6,559,679.5	-	-	-	-
11	Өмнөговь аймгийн МЭГ	2	171,897.4			2.0	171,897.4	2	171,897.4	-	-	-	-
	Дүн	30	11,427,750.4	2	114,563.2	28.0	11,313,187.2	28	11,427,750.4	2	-	2	-

5.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
		Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
А	Б	1	2	3	4	5	6.0	7	8	9	10	11	12	13
1	Мал эмнэлгийн ерөнхий газар ТТЗ	6	1,912,006.9			4	1,787,111.7	2	124,895.2					
2	Архангай аймгийн МЭГ	2	2,614.0			2	2,614.0							
3	Булган аймгийн МЭГ	5	34,431.2	3	25,913.8			2	8,517.4					
4	Баянхонгор аймгийн МЭГ	3	8,632.2	1	1,432.2	2	7,200.0							
5	Баянөлгий аймгийн МЭГ	1	1,471.0			1	1,471.0							
6	Говь-Алтай амйгийн МЭГ	2	5,745.0	1	310.7			1	5,434.3					
7	Говьсүмбэр аймгийн МЭГ	2	2,257.4			2	2,257.4							
8	Дархан-Уул аймгийн МЭГ	1	2,206.5					1	2,206.5					
9	Дорнод аймгийн МЭГ	1	1,471.0	1	1,471.0									
10	Дорноговь аймгийн МЭГ	4	43,839.4					4	43,839.4					
11	Дундговь аймгийн МЭГ	2	5,002.9	1	2,001.8	1	3,001.1							
12	Завхан аймгийн МЭГ	1	400.0	1	400.0									
13	Мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	3	23,844.7	1	1,238.5	1	12,106.2	1	10,500.0					
14	Мал эмнэлгийн ерөнхий газар ТШЗ	3	246,444.6			1	178,901.3	2	67,543.3					
15	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори	4	10,477.3					4	10,477.3					
16	Нийслэлийн МЭГ	2	734.1					2	734.1					
17	Орхон аймгийн МЭГ	7	12,536.2	1	2,609.5	2	3,919.3	4	6,007.4					
18	Сэлэнгэ аймгийн МЭГ	1	938.4					1	938.4					
19	Сүхбаатар аймгийн МЭГ	5	20,502.6	2	11,831.6	3	8,671.0							
20	Төв аймгийн МЭГ	6	1,327.9	3	831.0	1	-	2	496.9					
21	Увс аймгийн МЭГ	1	1,055.6	1	1,055.6									

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

22	Ховд аймгийн МЭГ	3	22,900.0	1	3,100.0			2	19,800.0					
23	Хөвсгөл аймгийн МЭГ	2	-					2	-					
24	Өвөрхангай аймгийн МЭГ	1	10,000.0			1	10,000.0							
25	Өмнөговь аймгийн МЭГ	4	18,189.8	1	1,160.2	2	17,029.6	1	-					
	НИЙТ ДҮН	72	2,389,028.7	18	53,355.9	23	2,034,282.6	31	301,390.2	-	-	-	-	-

5.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Албан шаардлага /Хариуцлага тооцуулах/			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хүний тоо
А	Б	1	2.0	3	4	5	6	7	8.0	9	10	11	12	13
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил														
1	Мал эмнэлгийн ерөнхий газар ТТЗ	1	-					1	-					
2	Дорнод аймгийн МЭГ	1	-					1						
3	Мал эмнэлгийн ерөнхий газар ТШЗ	1	1,668,282.3					1	1,668,282.30					
4	Нийслэлийн МЭГ	1	-			1	-							
5	Орхон аймгийн МЭГ	1	-					1	-					
6	Төв аймгийн МЭГ	1	40,174.7			1	40,174.70							
	Дүн	6	1,708,457.0	-	-	2	40,174.70	4	1,668,282.3	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил														
1	Мал эмнэлгийн ерөнхий газар ТТЗ	2	-			1	-	1	-					
2	Мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	2	26,278.4					2	26,278.4					
3	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори	1	21,544.5					1	21,544.5					
4	Хөвсгөл аймгийн МЭГ	1	-					1	-					
	Дүн	6	47,822.9	-	-	1	-	5	47,822.9	-	-	-	-	-
	НИЙТ ДҮН	12	1,756,279.9	-	-	3	40,174.7	9	1,716,105.2	0	-	0	0	-